



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: “ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН”**

**Аудит хийсэн  
үндэслэл,  
бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Газрын тосны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, 37 дугаар зүйлийн 37.2, 37.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/164 дүгээр тушаалаар баталсан аудитын жилийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв.

**ГАЗРЫН ТОСНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧ БОЛОН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ӨГСӨН ӨМНӨХ АУДИТЫН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ТОДОРХОЙ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

**Аудитын  
тайланг  
хүргүүлсэн:**

УИХ-ын Эдийн засгийн болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар



Улаанбаатар хот  
2024 он

## Аудитын зорилго, зорилтууд

Аудитаар газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх бөгөөд Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага шалгуурыг ханган, гэрээлэгч үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх, АМГТГ үнэн зөв хянаж дүгнэсэн эсэхийг үнэлэхэд аудитын зорилт оршино.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. АМГТГ нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, БХГ-ний дагуу анхан шатны баримт материалд үндэслэн хянаж хүлээж авсан эсэх;
2. АМГТГ нь гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, үнэн зөв дүгнэлт тайлан ирүүлсэн эсэх;
3. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан эсэх.

## Аудитын хамарсан хүрээ

Аудитаар АМГТГ-аас Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон өртөг нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын болон санхүүгийн тайланг хянан шалгаж, ирүүлсэн тайлан, дүгнэлтийн хүрээнд тухайн гэрээлэгчдийн анхан шатны баримт материал, санхүүгийн үйл ажиллагааг хамруулав.

Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 3 гэрээлэгч байгаа бөгөөд 2024 онд Ашигт малтмал, газрын тосны газраас хяналт шалгалтыг хийж дараах байдлаар дүгнэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн. Үүнд:

№	Гэрээлэгчийн нэр	Гэрээт талбайн нэр	Хяналт шалгалтад хамарсан он	АМГТГ-аас дүгнэлт ирүүлсэн огноо
1	Доншен газрын тос Монгол ХХК	БХГ-97	2019-2021 он	2023.12.28-ны 1/6109
2	Петроматад ХХК	Матад ХХ	2022 он	2024.06.11-ний 1/2566
3	Петрочайна Дачин Тамсаг ХХК	Тосон Уул XIX	2022 он	2024.06.14-ний 1/2634
4	Петрочайна Дачин Тамсаг ХХК	Тамсаг XXI		

Үүнээс Петрочайна Дачин Тамсаг ХХК-нд өгсөн өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, тодорхой шийдэлд хүрээгүй, мөн Тосон Уул XIX, Тамсаг XXI гэрээт талбайн 2022 оны нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг тулган баталгаажуулах талбарын ажлыг дуусгаж, гэрээний 2 талаас тайлбар, тодруулга авах зэрэг аудитын үе шатны ажил бүрэн дуусаагүй тул тус тайланд нэгтгэгдээгүй, харин Доншен газрын тос Монгол ХХК-ийн БХГ-97 гэрээт талбайн 2019-2021 он, Петроматад ХХК-ийн Матад ХХ гэрээт талбайн ашиглалтад шилжсэн 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оныг дуусгавар болгон аудитын тайланд хамруулсан.


## **БҮЛЭГ 1. ГЭРЭЭЛЭГЧИЙН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ ЗААВАР ЖУРАМГҮЙГЭЭС ХАРИЛЦАН АДИЛГҮЙ, ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭЭГҮЙ ДҮГНЭЛТИЙГ ИРҮҮЛЖ БАЙНА**

*АМГТГ нь гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлантай холбоотой анхан шатны нотлох баримт, тайлан мэдээг бүрэн авч хяналт хэрэгжүүлээгүй байна.*

### **1.1 ДОНШЕН ГАЗРЫН ТОС ХХК-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ БОЛОН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ:**

АМГТГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/120 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа Доншен газрын тос Монгол ХХК-ийн 2019-2021 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын тайланд хяналт шалгалт хийж, УАГ-т дүгнэлтийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/6109 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

Ирүүлсэн дүгнэлтийг хянаж үзэхэд гэрээлэгчийн төсөвлөсөн ажлын гүйцэтгэл 22 хувьтай байхад хийгдээгүй ажлын талаар дүгнээгүй, хөрөнгө оруулалт, ӨНЗ-ыг хамтруулан нэг бүлэг асуудал болгон тайлагнасан, ирээдүйд тосоор нөхөгдөх дүн зөрүүтэй, өдөр тутмын баримт 2 талын тооцоо нийлсэн протоколын дүн зөрүүтэй, тайлан болон зарим хүснэгтэн тооцооллыг боловсруулсан, хянасан албан тушаалтны нэр, гарын үсгээр баталгаажуулаагүй, тооцооллын зөрүүг ямар шалгуур үзүүлэлтэд нийцээгүй талаарх дүгнэлт тайлбар ирүүлээгүй байна.



Гэрээлэгчийн 2019-2021 онуудын ажлын төлөвлөгөө, төсөв 79,020,391.00 ам.доллароор батлагдаж, гүйцэтгэл 31,527,500.99 ам.доллар буюу 40.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

АМГТГ гэрээлэгчийн 2019-2021 оны гүйцэтгэлийг 17,672,742.33 ам.доллар буюу 22.3 хувийн гүйцэтгэлтэй гэж хянасан байна.

АМГТГ нь гэрээлэгчийн тайлант жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг хянаж баталсан ч гүйцэтгэлд цаг хугацаанд нь хяналт тавиагүйгээс төсвийн гүйцэтгэл нийт дүнгээр 22.3 хувьтай, энэ талаар санал дүгнэлт гаргаагүй нь Газрын тосны тухай хуулийн 9.1.3-д "газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих" гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

АМГТГ нь тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг гэрээлэгчийн анхан шатны баримтыг үндэслэн шалгаж, төлбөр төлөөгүй гэж ӨНЗ-аас хассан 7,463,787.38 ам.доллар хассан боловч анхан шатны баримтыг бүрэн хянаагүй 5,718,941.94 ам.долларын зардлыг зөрүүтэй хянасан байна.

*Гэрээний талууд мөнгөөр төлөгдөөгүй ажлын гүйцэтгэлийг тухай бүр тооцоо нийлж баталгаажуулаагүй, бүртгэл хяналт сул байгаагаас дээрх нөхцөл байдал үүссэн байна.*

### **1.2 ПЕТРОМАТАД ХХК-ИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ БОЛОН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ:**

АМГТГ-ын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж

байгаа **Петроматад ХХК-ийн Матад ХХ** гэрээт талбайд 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын тайланд анхан шатны баримтад үндэслэн хяналт шалгалт хийж, ҮАГ-т дүгнэлт тайланг 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 1/2566 дугаар албан бичгээр ирүүлсэн.

АМГТГ-ын дүгнэлтэд БХГ-ний 15.3<sup>1</sup> -т заасан хяналт шалгалтын хэрэгжилтийг гэрээлэгчийн ирүүлсэн тайлан, мэдээг үндэслэсэн талаар дурдсан ч ямар тайланг хэдий хугацаанд хүлээн авсан талаарх бүртгэл байхгүй, төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийн хувь дутуу байгаа шалтгааны талаар тодорхой тайлбар оруулаагүй байна.

Гэрээлэгч нь 2021 оны 7-12 сар, 2022 онуудад гүйцэтгэх жилийн ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг АМГТГ-т хүргүүлэн нийт 4,029,891.00 ам.доллаар батлуулсан байна.

Гэрээлэгчийн 2021.07.01-2022 оны ӨНЗ-ын ажлын төлөвлөгөө, төсөв 3,869,764.00 ам.доллаар батлагдаж, гүйцэтгэл 1,510,856.74 ам.доллар буюу 39.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

АМГТГ-ын гэрээлэгчийн төлөвлөгөө, төсвийн гүйцэтгэлийг 1,385,910.13 ам.доллар буюу 35.8 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Аудитаар гэрээлэгчийн төсвийн гүйцэтгэлийг өртөг нөхөгдөх зардлын тайланд үндэслэн АМГТГ-ын хянасныг зэрэгцүүлэн шалгаж, гэрээлэгчийн төсвийн гүйцэтгэл 1,344,179.42 ам.доллар байна гэж тогтоов.

**БҮЛЭГ 2. ГЭРЭЭЛЭГЧ ӨМНӨХ АУДИТЫН БОЛОН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭЭГҮЙГЭЭС ТООЦООЛЛЫГ ЗӨРҮҮТЭЙ ТАЙЛАГНАСАН ХЭВЭЭР, АМГТГ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ АНХАН ШАТНЫ БАРИМТЫГ БҮРЭН ХАМРУУЛААГҮЙГЭЭС ӨНЗ-Д ЗӨРҮҮ ҮҮСЭЖ, МУ-Д НООГДОХ ТОСНЫ ХУВААРИЛАЛТАД НӨЛӨӨЛӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.**

*Гэрээлэгч нь өртөг нөхөгдөх зардлын тайланг тайлагнахдаа зарим зардлыг холбогдох хууль тогтоомж болон “БХГ-97”-ний заалтыг дагаж мөрдөөгүй байна.*

## 2.1. ДОНШЕН ГАЗРЫН ТОС МОНГОЛ ХХК-ИЙН БХГ-97 талбай /2019-2021 он/

**Олборлолт:** Гэрээлэгч нь 2019-2021 онд БХГ-97 талбайд 1,299,563.5 баррель газрын тос олборлохоор төлөвлөснөөс 1,066,556.7 баррелийг олборлож 233,006.8 баррель тос дутуу буюу 82.1 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

### БХГ-97 талбайн газрын тосны олборлолтын төлөвлөгөө, гүйцэтгэл

/баррель/

Огноо	Гэрээлэгч				АМГТГ-ын дүгнэлт /гүйцэтгэлээр/	Аудит /гүйцэтгэлээр/	зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь			
2019	375,500.5	376,072.3	571.8	100.2	376,072.3	376,072.3	-
2020	500,500.9	365,218.0	(135,282.9)	73.0	365,218.0	365,218.0	-
2021	423,562.1	325,266.4	(98,295.7)	76.8	325,266.4	325,266.4	-
<b>Дүн</b>	<b>1,299,563.5</b>	<b>1,066,556.7</b>	<b>(233,006.8)</b>	<b>82.1</b>	<b>1,066,556.7</b>	<b>1,066,556.7</b>	

*АМГТГ-аас ирүүлсэн дүгнэлтийг хянаж үзэхэд төлөвлөгөө гүйцэтгэлийн болон газрын тосны хэвийн хорогдлын зөрүү, ус ашиглалтын хяналтыг сайжруулах шаардлагатай байна.*

**Ус ашиглалтын тооцоо:** Гэрээлэгч болон АМГТГ-ын 2019-2021 оны “Хий, тос, усны олборлолт, ачилт буулгалтын хэмжээг баталгаажуулсан протокол”-ын 4 дүгээр хавсралтад ус шахалтын үйл ажиллагаанд 2019-2021 онд хэрэглэсэн 1,151,045.0 м<sup>3</sup> усны тооцоог нийт дүнгээр нь баталгаажуулсан. Протоколд жил бүрийн эцэст цооногууд болон байгууламжид байгаа усны үлдэгдлийг хэмжээгүй, усны орлого, зарлагын тооцоог хийж баталгаажуулаагүй байна.

<sup>1</sup> Санхүүгийн хяналт-15.3.1-д гэрээний 15.2-т заасан тайлан, мэдээг МУ-ын хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу үнэн зөв бүртгэж, тайлагнаж байгаа байдалд төрийн захиргааны байгууллага байнгын хяналт тавьж ажиллана

Ус ашиглах гэрээний дагуу сар бүр худаг, цооногоор ашигласан усыг тоолуурын заалтаар баталгаажуулсан акт, жилийн эцэст усны хэрэглээг нэгтгэн тооцоо нийлсэн акт үйлдэж Зүүн-Баян сумын татварын улсын байцаагч, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны ЗТХХБОХТ хариуцсан мэргэжилтэн, Доншен газрын тос Монгол ХХК-ийн Үйлдвэрлэлийн баазын БОХХЭА хариуцсан ажилтан нар баталгаажуулдаг. Дээрх сар бүрийн болон жилийн эцсийн дүнгээр хийсэн актууд хоорондоо 119,363.00 м3 усны зөрүүтэй байна.

Гэрээлэгчдийн газрын тос олборлох технологид ашиглагдаж буй усны заалт болон төлбөрийн нэхэмжлэхийг цооног, худгийн байршлаар нь ангилж нэгтгэж нийт ашигласан усны тооцоог гаргаж, оролцогч талуудын жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж акт үйлдэх, тус аудитаарх акт болон гэрээлэгчийн АМГТГ-тай хийсэн протоколын дүнгийн зөрүүг тодорхойлж, арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж өглөө.

**Газрын тосны экспорт:** Гэрээлэгч 2019-2021 онд нийт 975,589.83 баррель газрын тос экспортолсныг хөндлөнгийн хяналтын Амбер ХХК-ийн хэмжилтээр баталгаажуулсан байна. Гэрээлэгч, АМГТГ-ын баталгаажуулсан протоколын 3 дугаар хавсралтаар экспортын тосны ачилт буулгалтыг баталгаажуулахад 257 нэгжээр зөрүүтэй байгаа нь хятад вагоны хэмжээ бага учир шилжүүлэх ачихад вагоны тоо нэмэгддэг, хятад вагонууд тосны үлдэгдэлтэй ирдэг учир 2,987.82 баррель тосны илүүдэлтэй байна. Экспортын ачилтаас буцаж ирсэн 2,613.18 баррель тосыг тосны орлого, зарлагын тооцоонд оруулж тооцдог байна.

**Борлуулалтын зардал:** Гэрээлэгч нь 2019-2021 онд нийт 7,491,278.75 ам.долларын борлуулалтын зардлыг тээвэр, шилжүүлэлт, үйл ажиллагаа /цалин, цахилгаан, туслах материал/-ны зардал гэж ангилан бүртгэж, тайлагнасан байна.

АМГТГ-ын хяналт шалгалтаар борлуулалтын зардлаас 4,703,739.62 ам.долларыг хасаж, 2,787,539.12 ам.доллар гэж дүгнэсэн байна.

Аудитаар 3,695,861.40 ам.доллар хасаж, АМГТГ-ын хяналт шалгалтаар хассан дүнгээс зөрсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Шилжүүлэлтийн зардалд АМГТГ нь 2019-2021 оны ачилт буулгалтын болон борлуулалтын шимтгэл, вагоны халдваргүйжилтийн зардал 728,324.05 ам.долларын зардлыг ӨНЗ-д оруулж, 131,671.38 ам.долларын зардлыг ӨНЗ-аас хассантай холбоотойгоор зөрүү үүссэн бөгөөд дээрх зардлууд нь борлуулалтын шилжүүлэн ачихад хамааралтай зардал тул аудитаар ӨНЗ-д оруулсан;
2. Туслах материалын зардалд тос ачихад халааж ус тос ялгах, шинжилгээ лаборатори, түүхий тос ачиж, буулгах насос ажиллуулах зэрэг үйл ажиллагаатай холбоотой зардлыг оруулсан;
3. Гэрээлэгчээр борлуулалтын ажилтнуудын цалингийн зардлыг танкфармын цалингийн нийт зардлаас ялгуулж тулгалт хийхэд 706,548.22 ам.долларын хятад ажилчдад олгосон цалин зардал гарсан байсныг АМГТГ-ын мэргэжилтнүүдээс лавлахад борлуулалтад хамаарах хятад ажилтнуудын цалингийн файлыг ирүүлсэн. Монгол ажилчдын цалинг гэрээлэгчийн цалингийн хүснэгтээс, хятад ажилчдын цалинг АМГТГ-ын мэргэжилтнүүдийн ангилсан хүснэгтээс тооцож оруулсан.

Аудитаар БХГ-ний 8.4.в-д нийцүүлэн Танкфармыг экспортын цэг гэж тооцсон учир гэрээлэгчийн тайлагнасан нийт борлуулалтын зардлаас Зүүнбаян танкфармын боловсруулалтын төвийн зардал 3,695,861.40 ам.долларыг хасаж тооцсон. Үүнээс өртөг нөхөгдөх зардалд 3,454,730.62 ам.долларын зардлыг залруулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал, давхардуулан тооцсон үйл ажиллагааны зардлын 241,130.78 ам.долларын зардлыг хасаж тооцов.

Аудитаар гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлын ангиллын дагуу тухайн онд мөнгөөр төлөгдсөн, борлуулалтын үйл ажиллагаанд хамаарах зардлуудыг тооцоолж, 3,795,417.35 ам.доллаароор борлуулалтын зардлыг баталгаажууллаа.

### **Газрын тосны борлуулалтын орлого:**

Гэрээлэгч 2019-2021 онд нийт 1,003,983.27 баррель түүхий газрын тосыг борлуулсан байна. Гэрээлэгч тухайн онд борлуулсан тосны хэмжээг тооцохдоо өмнөх оны 1 дүгээр сард

худалдан авагч хүлээн авсан тосыг нэмж, тайлант оны 12 дугаар сарын сүүлээр ачуулж дараа оны эхээр худалдан авагч тал хүлээн авсан 79,640.31 баррель тосыг хасаж тооцоолсон байна.

Гэрээлэгч БХГ-97 талбайгаас олборлосон түүхий тосыг худалдах, худалдан авах гэрээг Хятадын Эрээн хотын Гаоули олон улсын эдийн засаг, худалдааны компанитай 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдөр DS/VL/07-2017 гэрээг байгуулсан бөгөөд энэхүү гэрээний хугацаанд газрын тосны худалдан авах үнэ нь тухайн сарын туршид Платс сэтгүүлд хэвлэгдсэн DMD brent газрын тосны дундаж баррель тутамд 2019 онд 5.20 ам.доллар, 2020 онд 3.20 ам.доллар, 2021 онд 7.20 ам.долларыг тээвэр, борлуулалтын зардалд тооцон хасахаар, нэмэлт ерөнхий нөхцөлийн хэсэг 6.2-т заасан үнийн шаардлагатай тохируулгыг хийсэнтэй тэнцүү байна гэж тохирсон байна.

Гэрээлэгч нь 2019-2021 онд нийт 1,003,983.27 баррель түүхий тос борлуулж, 52,454,619.38 ам.долларын борлуулалтын орлогоос 7,491,278.75 ам.долларын борлуулалтын зардлыг хасаж, нийт борлуулалт 44,963,340.63 ам.долларыг тайлагнасан байна.

### Хүснэгт 16. БХГ-97 Борлуулалтын орлогын тооцоо

/ам.доллар/

ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОН			
	2019	2020	2021	НИЙТ
<b>ГЭРЭЭЛЭГЧИЙН ТАЙЛАГНАСАН:</b>				
Борлуулсан тосны хэмжээ /брл/	350,730.17	372,587.26	280,665.84	1,003,983.27
Борлуулсан тосны орлого /ам.доллар/	20,381,342.15	13,927,063.52	18,146,213.71	52,454,619.38
Борлуулалт, тээврийн зардал	2,491,210.69	2,522,677.43	2,477,390.63	7,491,278.75
1 брл тосны борлуулалт, тээврийн зардал /дундаж/	7.27	6.87	9.78	-
<b>Цэвэр борлуулалт</b>	<b>17,890,131.46</b>	<b>11,404,386.09</b>	<b>15,668,823.08</b>	<b>44,963,340.63</b>
<b>АМГТГ-ЫН ДҮГНЭЛТ:</b>				
Борлуулсан тосны хэмжээ /брл/	350,730.17	372,587.26	280,665.84	1,003,983.27
Борлуулсан тосны орлого /ам.доллар/	20,381,342.15	13,927,063.52	18,146,213.71	52,454,619.38
Борлуулалт, тээврийн зардал	1,002,689.18	925,250.91	859,599.03	2,787,539.12
1 брл тосны борлуулалт, тээврийн зардал /дундаж/	2.86	2.48	3.06	-
<b>Цэвэр борлуулалт</b>	<b>19,378,652.97</b>	<b>13,001,812.61</b>	<b>17,286,614.68</b>	<b>49,667,080.26</b>
<b>АУДИТААР:</b>				
Борлуулсан тосны хэмжээ /брл/	350,730.17	372,587.26	280,665.84	1,003,983.27
Борлуулсан тосны орлого /ам.доллар/	20,381,342.15	13,927,063.52	18,146,213.71	52,454,619.38
Борлуулалт, тээврийн зардал	1,312,625.94	1,192,123.64	1,290,667.77	3,795,417.35
1 брл тосны борлуулалт, тээврийн зардал /дундаж/	3.74	3.20	4.60	-
<b>Цэвэр борлуулалт</b>	<b>19,068,716.21</b>	<b>12,734,939.88</b>	<b>16,855,545.94</b>	<b>48,659,202.03</b>
<b>ЗӨРҮҮ:</b>				
<b>АМГТГ-Гэрээлэгч</b>	<b>1,488,521.51</b>	<b>1,597,426.52</b>	<b>1,617,791.60</b>	<b>4,703,739.63</b>
<b>АУДИТ-Гэрээлэгч</b>	<b>1,178,584.75</b>	<b>1,330,553.79</b>	<b>1,186,722.86</b>	<b>3,695,861.40</b>

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, УАГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд

АМГТГ-ын шалгалтаар гэрээлэгчийн тайлагнасан борлуулалтын зардлаас 4,703,739.63 ам.долларыг хасаж тооцсон тооцооллоос үндэслэн борлуулалтын орлогыг 49,667,080.26 ам.доллаароор дүгнэсэн байна.

Аудитаар тосны борлуулалтыг экспортын ачилт буулгалтын бүртгэл мэдээнд үндэслэн тооцооллыг давтан гүйцэтгэж, борлуулалтын орлогыг баталгаажуулахад гэрээлэгчийн борлуулалтын нэхэмжлэх, гэрээлэгч болон АМГТГ-ын тооцоо нийлж баталгаажуулсан борлуулалтын тайлантай тулгаж шалгахад Гэрээлэгчээс Платцын үнийн мэдээг гаргуулж борлуулалтын гэрээ болон борлуулалтын тайлангаарх тооцоололтой нийцэж байгааг хянаж, гэрээлэгчийн илүү тайлагнасан борлуулалтын зардал 3,695,861.40 ам.долларыг хасаж, тооцон нийт борлуулалтыг 48,659,202.03 ам.доллаароор тооцов.

### 2.2. БХГ-97 ТАЛБАЙН 2019-2021 ОНЫ ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ:

**АМГТГ хяналт шалгалт хэрэгжүүлэхдээ анхан шатны баримтыг бүрэн хамруулаагүйгээс ӨНЗ-ыг дутуу хянасан байна.**

Гэрээлэгч БХГ-ний 2019-2021 оны тайланд газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд нийт 31,527,500.09 ам.долларын өртөг нөхөгдөх зардал тайлагнасныг АМГТГ хянаж 17,672,742.33 ам.доллар гэж дүгнэсэн.

### Хүснэгт 17. БХГ-97 талбайн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардал

/ам.доллар/

Он	ӨНЗ			Зөрүү /+ өсөх, - буурах/		
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Аудит АМГТГ	Гэрээлэгч-АМГТГ	Гэрээлэгч-Аудит
2019	15,654,375.83	7,552,563.79	11,721,922.99	4,169,359.20	-8,101,812.04	-3,932,452.84
2020	7,658,092.45	4,795,643.03	5,575,799.26	780,156.23	-2,862,449.42	-2,082,293.19
2021	8,215,032.71	5,324,535.52	6,093,962.02	769,426.50	-2,890,497.19	-2,121,070.69
<b>Дүн</b>	<b>31,527,500.99</b>	<b>17,672,742.33</b>	<b>23,391,684.27</b>	<b>5,718,941.93</b>	<b>-13,854,758.66</b>	<b>-8,135,816.72</b>

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, УАГ-т ирүүлсэн дүгнэлт, УАГ-ын аудитын дүн

Аудитаар гэрээлэгчийн өртөг нөхөгдөх зардлын тайлангийн ажил гүйлгээнүүдийг хууль тогтоомж, гэрээний шаардлагыг хангасан эсэхийг тулган шалгаж АМГТГ-ын төлбөр төлөөгүй гэж ӨНЗ-аас 7,463,787.38 ам.доллар хассаныг аудитаас анхан шатны баримтыг бүрэн хянаагүй 5,718,941.94 ам.долларыг зөрүүтэй асуудлыг шийдвэрлэж, цаашид үнэн зөв тайлан, дүгнэлт ирүүлэх зөвлөмж өглөө.

Аудитаар гэрээлэгчийн тайлагнасан ӨНЗ-ын тайланг БХГ-ний хавсралт В “Нягтлан бодох бүртгэлийн тооцооны журам”, МУЗГ-ын 2019 оны 178 дугаар тогтоолоор баталсан “Газрын тосны бүртгэл, тооцооны журам”-д нийцүүлэн шалгаж ангиллын дагуу өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй 8,135,816.72 ам.долларыг хасаж, борлуулалтын зардлаас хассан 3,454,730.62 ам.долларыг нэмж залруулсан. Эх компанийн захиргааны нэмэгдэл зардлыг БХГ-ний дагуу тооцоолсон өртөг нөхөгдөх зардлын 6.0 хувиар тооцон 1,610,784.89 ам.долларыг нэмэгдүүлэн нийт 28,457,199.78 ам.доллаароор өртөг нөхөгдөх зардлыг тооцов. Хүснэгтээр харуулбал:

### Хүснэгт 19. БХГ-97 талбайн 2019-2021 оны өртөг нөхөгдөх зардлын баталгаажуулалт

/ам.доллар/

Хөрөнгө оруулалт-өртөг нөхөгдөх зардал	Зэрэгцүүлэлт			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч-АМГТГ	Гэрээлэгч-Аудит
Өртөг нөхөгдөх зардал /тайлангаар/	<b>31,527,500.99</b>	<b>31,527,500.99</b>	<b>31,527,500.99</b>	-	-
Хяналт,шалгалтаар хасагдсан дүн	-	13,854,758.65	8,135,816.72	13,854,758.65	8,135,816.72
Тос борлуулалттай холбогдох зардлаас шилжүүлсэн дүн	-	4,602,238.65	3,454,730.62	4,602,238.65	3,454,730.62
<b>ӨНЗ-ын дүн</b>	<b>31,527,500.99</b>	<b>22,274,980.99</b>	<b>26,846,414.89</b>	<b>(9,252,520.00)</b>	<b>(4,681,086.10)</b>
Захиргааны зардал 6%	1,891,747.34	1,336,498.86	1,610,784.89	555,248.48	280,962.45
<b>Нийт дүн</b>	<b>33,419,248.33</b>	<b>23,611,479.85</b>	<b>28,457,199.78</b>	<b>(9,807,768.48)</b>	<b>(4,962,048.55)</b>

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, УАГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд

### Өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын тооцоолол:

Аудитаар баталгаажуулсан нийт өртөг нөхөгдөх зардал 28,457,199.78 ам.доллаароос 2019-2021 онд өртөгт тосоор нөхөгдсөн дүн 19,320,145.11 ам.доллар, нөхөгдөх зардлын дүнг 9,137,054.67 ам.доллаароор тус тус тооцов.

### Хүснэгт 20. БХГ-97 талбайн Өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын тооцоолол

/ам.доллар/

Хөрөнгө оруулалт- өртөг нөхөгдөх зардал	Зэрэгцүүлэлт			Зөрүү	
	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Гэрээлэгч- АМГТГ	Гэрээлэгч- Аудит
Өртөг нөхөгдөх зардал /тайлангаар/	<b>31,527,500.99</b>	<b>31,527,500.99</b>	<b>31,527,500.99</b>	-	-
Хяналт,шалгалтаар хасагдсан дүн	-	13,854,758.65	8,135,816.72	13,854,758.65	8,135,816.72
Тос борлуулалттай холбогдох зардлаас шилжүүлсэн дүн	-	4,602,238.65	3,454,730.62	4,602,238.65	3,454,730.62
<b>ӨНЗ-ын дүн</b>	<b>31,527,500.99</b>	<b>22,274,980.99</b>	<b>26,846,414.89</b>	<b>(9,252,520.00)</b>	<b>(4,681,086.10)</b>
Захиргааны зардал 6%	1,891,747.34	1,336,498.86	1,610,784.89	555,248.48	280,962.45
<b>Нийт дүн</b>	<b>33,419,248.33</b>	<b>23,611,479.85</b>	<b>28,457,199.78</b>	<b>(9,807,768.48)</b>	<b>(4,962,048.55)</b>
Тухайн жилд өртөгт тосоор нөхөгдсөн дүн	17,793,614.34	19,717,578.83	19,320,145.11	1,923,963.66	1,526,530.77
<b>Өртөг нөхөгдөх зардлын нийт дүн</b>	<b>15,625,633.99</b>	<b>3,893,901.02</b>	<b>9,137,054.67</b>	<b>(11,731,732.97)</b>	<b>(6,488,579.32)</b>

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, ҮАГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд

Гэрээлэгчийн тайлагнасан 2019-2021 оны борлуулалтын зардлыг АМГТГ-ын хяналт шалгалтаар 2,787,539.13 ам.доллар, аудитаар 3,795,417.35 ам.доллаароор баталгаажуулснаас шалтгаалан МУЗГ болон гэрээлэгчийн үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүнгүүд зөрүүтэй байна.

Өмнөх оны аудитын тайлангаар 2018 оны эцэст МУЗГ-ын нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 4,054,265.46 ам.доллаароор баталгаажуулсан байна. 2019-2021 оны өртөгт тосны нөхөлт 143,535.70 ам.доллар болж, 2021 оны эцэст нийт 4,197,801.16 ам.долларын хөрөнгө оруулалтыг өртөгт тосоор нөхсөн байна.

Аудитаар 2021 оны жилийн эцсийн байдлаар МУЗГ-ын нийт өртөг нөхөгдөх зардлын үлдэгдэл буюу ирээдүйд тосоор нөхөх хөрөнгө оруулалтыг 839,817.84 ам.доллаароор баталгаажууллаа.

АМГТГ-ын хяналт шалгалт болон аудитаар хасаж тооцсон борлуулалтын зардлын тооцооллоос шалтгаалан МУЗГ-ын үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн 5,717.57 ам.доллаароор зөрүүтэй байна.

## Хүснэгт 22. БХГ-97 талбайн МУЗГ-ын хөрөнгө оруулалтын тооцоолол

/ам.доллар/

№	Үзүүлэлт	АМГТГ	Аудит	Зөрүү /Аудит-АМГТГ/	
1	МУЗГ-ын анх оруулсан хөрөнгө оруулалт	<b>5,037,619.00</b>	<b>5,037,619.00</b>	-	
2	Анх оруулсан хөрөнгө оруулалтыг 2003-2021 онуудад нөхсөн байдал	2003-2018	4,054,265.46	4,054,265.46	
		2019	62,244.23	61,248.71	(995.52)
		2020	38,537.37	36,574.75	(1,962.62)
		2021	48,471.67	45,712.24	(2,759.43)
3	Нийт нөхсөн хөрөнгө оруулалт	<b>4,203,518.73</b>	<b>4,197,801.16</b>	<b>(5,717.57)</b>	
4	Үлдсэн хөрөнгө оруулалт буюу ирээдүйд тосоор нөхөгдөх дүн	<b>834,100.27</b>	<b>839,817.84</b>	<b>5,717.57</b>	

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, ҮАГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд

Аудитаар 2021 оны жилийн эцсийн байдлаар гэрээлэгчийн нийт өртөг нөхөгдөх зардлын үлдэгдэл буюу ирээдүйд тосоор нөхөх хөрөнгө оруулалтыг нийт борлуулалтын орлогын тооцооллын зөрүүгээс шалтгаалан АМГТГ-ын баталгаажуулалтаас 5,243,153.89 ам.доллаароор зөрүүтэй буюу 130,600,784.96 ам.доллар байна.

### 2.3. БХГ-97 ТАЛБАЙН 2019-2021 ОНЫ МУЗГ-Т ТӨЛӨХ РОЯЛТИ , БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААЛТ, ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭЛТ:

**АМГТГ-ын шалгалтаар тооцооллын зөрүүгээс үүссэн роялти, тосны орлогын нөхөн төвлөрүүлэлт, гэрээлэгчийн орлогын дутуу төвлөрүүлэлтэд санал, дүгнэлт гаргаагүй байна.**

**МУЗГ-т төлөх нөөцийн төлбөр /Роялти/,**

Гэрээлэгч 2019-2021 оны нийт борлуулалт 44,963,340.63 ам.долларыг тайлагнаж, МУЗГ-т нөөц ашигласны төлбөрт 3,372,250.55 ам.доллар ногдуулан төлөхөөр тооцсон байна.

АМГТГ-ын шалгалтаар 2019-2021 оны нийт борлуулалтыг 49,667,080.26 ам.доллар, үүнээс МУЗГ-т нөөц ашигласны төлбөрт 3,725,031.02 ам.доллар ногдуулан төлөхөөр дүгнэсэн байна.

**Хүснэгт 24. БХГ-97 талбайн 2019-2021 оны МУЗГ-т төлөх роялти тооцоо**

*/ам.доллар/*

Огноо	Гэрээлэгч		АМГТГ		Аудит		Зөрүү	
	Нийт борлуулалт	Роялти	Нийт борлуулалт	Роялти	Нийт борлуулалт	Роялти	Гэрээлэгч-АМГТГ	Гэрээлэгч-Аудит
2019	17,890,131.46	1,341,759.86	19,378,652.97	1,453,398.97	19,068,716.21	1,430,153.72	(111,639.11)	(88,393.86)
2020	11,404,386.09	855,328.96	13,001,812.61	975,135.95	12,734,939.88	955,120.49	(119,806.99)	(99,791.53)
2021	15,668,823.08	1,175,161.73	17,286,614.68	1,296,496.10	16,855,545.94	1,264,165.95	(121,334.37)	(89,004.21)
<b>ДҮН</b>	<b>44,963,340.63</b>	<b>3,372,250.55</b>	<b>49,667,080.26</b>	<b>3,725,031.02</b>	<b>48,659,202.03</b>	<b>3,649,440.15</b>	<b>(352,780.47)</b>	<b>(277,189.61)</b>

*Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, YAГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд*

Аудитаар гэрээлэгчийн борлуулалтын орлогын тайланг шалгаж, нийт борлуулалтын орлогын тооцооллын зөрүүнээс үүдэн БХГ-ний дагуу МУЗГ-т төлөх нөөц ашигласны төлбөр /роялти/-т 277,189.61 ам.долларыг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**Бүтээгдэхүүн хуваалт:**

Гэрээлэгч БХГ-97 талбайгаас 2019-2021 онд нийт 1,003,983.27 баррель тос экспортолж, 44,963,340.63 ам.долларын борлуулалтын орлого тайлагнаснаас МУЗГ-т 3,372,250.55 ам.долларын газрын тосны нөөц ашигласны төлбөр, 191,721.91 ам.долларын өртөгт газрын тос, 9,147,229.61 ам.долларын ашигт газрын тос нийт 12,711,202.07 ам.долларын орлого ногдох тайлан ирүүлсэн.

**Хүснэгт 25. БХГ-97 талбайн 2019-2021 оны бүтээгдэхүүн хуваах тооцоо**

*/ам.доллар/*

№	Утга	Мөр дугаар	Гэрээлэгч	АМГТГ	Аудит	Зөрүү	
						Гэрээлэгч-АМГТГ	Гэрээлэгч-Аудит
1	Экспортолсон тос (баррель)	А	1,003,983.27	1,003,983.27	1,003,983.27	-	-
2	Борлуулсан тосны үнэ	Б	52,454,619.38	52,454,619.38	52,454,619.38	-	-
3	Нийт борлуулалтын зардал	В	7,491,278.75	2,787,539.13	3,795,417.35	4,703,739.62	3,695,861.40
4	"БХГ-97"-ний 8.4 в-ийн дагуу тооцсон дүн буюу цэвэр борлуулалт	Г /Б-В/	44,963,340.63	49,667,080.25	48,659,202.03	(4,703,739.62)	(3,695,861.40)
5	Роялти	Д /Г*7.5%/	3,372,250.55	3,725,031.02	3,649,440.15	(352,780.47)	(277,189.61)
6	<b>Өртөгт газрын тос</b>	<b>Е /Г*40%/</b>	<b>17,985,336.25</b>	<b>19,866,832.10</b>	<b>19,463,680.81</b>	<b>1,881,495.85</b>	<b>1,478,344.56</b>
	МУЗГ-т ногдох	Ё	191,721.91	149,253.27	143,535.70	(42,468.64)	(48,186.21)
	Гэрээлэгчид ногдох	Ж	17,793,614.34	19,717,578.83	19,320,145.11	1,923,964.49	1,526,530.77
7	<b>Ашигт газрын тос</b>	<b>З /Г-Д-Е/</b>	<b>23,605,753.83</b>	<b>26,075,217.13</b>	<b>25,546,081.07</b>	<b>2,469,463.30</b>	<b>1,940,327.24</b>
	МУЗГ-38.75%	И	9,147,229.61	10,104,146.64	9,899,106.42	956,917.03	751,876.81
	Гэрээлэгч-61.25%	Й	14,458,524.22	15,971,070.49	15,646,974.65	1,512,546.27	1,188,450.43
8	<b>МУЗГ-т ноогдох дүн</b>	<b>К</b>	<b>12,711,202.07</b>	<b>13,978,430.93</b>	<b>13,692,082.27</b>	<b>1,267,228.86</b>	<b>980,880.21</b>
	Роялти	Л	3,372,250.55	3,725,031.02	3,649,440.15	352,780.47	277,189.60

	Ашигт газрын тос	М	9,147,229.61	10,104,146.64	9,899,106.42	956,917.03	751,876.81
	Өртөгт газрын тос	Н	191,721.91	149,253.27	143,535.70	(42,468.64)	(48,186.21)
<b>9</b>	<b>Гэрээлэгчид ноогдох дүн</b>	<b>О</b>	<b>32,252,138.56</b>	<b>35,688,649.32</b>	<b>34,967,119.76</b>	<b>3,436,510.76</b>	<b>2,714,981.20</b>
	Өртөгт газрын тос	Ө	17,793,614.34	19,717,578.83	19,320,145.11	1,923,964.49	1,526,530.77
	Ашигт газрын тос	П	14,458,524.22	15,971,070.49	15,646,974.65	1,512,546.27	1,188,450.43

Эх сурвалж: АМГТГ-аас гэрээлэгчийн 2019-2021 оны газрын тосны олборлолт, экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланг шалгаж, ҮАГ-т ирүүлсэн дүгнэлт, холбогдох ажлын баримтууд

АМГТГ-ын шалгалтаар МУЗГ-т ногдох нийт орлогыг 13,978,430.93 ам.доллар, аудитаар 13,692,082.27 ам.доллар гэж тус тус баталгаажуулсан нь тооцооллын зөрүүгээс шалтгаалан 286,348.65 ам.долларын зөрүүтэй байна.

Аудитаар МУЗГ-т ногдох нийт орлого 13,692,082.27 ам.доллар төвлөрүүлэхээс роялти 3,649,440.15 ам.доллар, ашигт газрын тос 9,899,106.42 ам.доллар, өртөгт газрын тосыг 143,535.70 ам.доллар гэж баталгаажуулсан.

#### **Орлого төвлөрүүлэлт:**

Гэрээлэгч БХГ-97 талбайн МУЗГ-т ноогдох нөөц ашигласны төлбөр 3,372,250.55 ам.доллар, өртөгт тос 191,721.91 ам.доллар, ашигт тосны 3,147,229.61 ам.доллар нийт 12,711,202.07 ам.долларын орлого ногдуулахаар тайлагнасан байна.

Гэрээлэгч нь МУЗГ-т ногдох 2019-2021 оны орлогыг АМГТГ-ын Төрийн сан банкны 100900000752 дансанд 11,501,183.31 ам.долларыг тайлант хугацаанд шилжүүлж, 2022 онд 811,843.26 ам.доллар, 2023 онд 397,126.17 ам.долларыг тус тус шилжүүлж, 1,049.33 ам.долларыг дутуу төвлөрүүлсэн байна.

Аудитаар Гэрээлэгчээс нийт нөхөн төвлөрүүлэх 981,929.53 ам.доллар, үүнээс дутуу төлсөн 1,049.33 ам.доллар, роялти 277,189.61 ам.доллар, тосны орлого 703,690.59 ам.доллар гэж баталгаажуулж, дараах төлбөрийн актыг тогтоолоо. Үүнд:

1. Борлуулалтын зардлыг илүү тайлагнасан 3,695,861.40 ам.долларыг хасаж тооцсонтой холбоотой нийт борлуулалт нэмэгдэж, Монгол Улсын Засгийн Газарт нөхөн төлөхөөр тооцоноос дутуу төлсөн роялти болох 277,189.60 ам.долларыг нөхөн төлүүлэх;
2. Монгол Улсын Засгийн Газарт ногдох ашигт газрын тосны дутуу төвлөрүүлсэн 703,690.59 ам.долларыг нөхөн төлүүлэх;
3. Монгол Улсын Засгийн Газарт ногдох тосны орлогыг 2020 онд 1,049.33 ам.доллаар дутуу төвлөрүүлсэн тул нөхөн төлүүлэх;

#### **2.4. ПЕТРОМАТАД ХХК-ИЙН МАТАД ХХ ТАЛБАЙН БХГ-НИЙ ХУГАЦААГ ТОДОРХОЙ БОЛГОЖ, АШИГЛАЛТАД ШИЛЖСЭН ҮЕИЙН ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДАХИН ХЯНАЖ ИРҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

АМГТГ-ын дүгнэлтээр ирүүлсэн Матад ХХ талбайн аудитаар баталгаажуулсан 2017-2018 оны ӨНЗ-ын дүн зөрүүтэй, 2021 оны ашиглалтад шилжсэн үеийн зардлыг хайгуулын ӨНЗ-ын дүнтэй давхардуулан тооцсон байна.

Мөн 2022 оны ӨНЗ-ыг 6,313.05 ам.доллаар зөрүүтэй хянаж дүгнэсэн, “Петроматад ХХК”-ийн Матад ХХ талбайн 2022 оны дүгнэлтээр АМГТГ, “Петроматад инвест лимитед”-ийн хооронд 2018 оны 6 дугаар сарын 8-ны өдөр шинэчлэн байгуулсан гэрээний хайгуулын хугацааг хөөж тооцоход гэрээнд заасан хайгуулын хугацаа хэтэрсэн, 2021 онд ашиглалтад шилжсэн атал өнөөг хүртэл олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй байгаа нь БХГ-ний 7 дугаар зүйлд заасантай нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл хайгуулын хугацаанаас ашиглалтын хугацаанд шилжих БХГ-ний заалтуудыг мөрдөөгүй, БХГ-нд заасан хугацаанд олборлох үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар хугацааны хоцрогдлыг арилгах талаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа тул тус гэрээлэгчийн ӨНЗ-ыг баталгаажуулах боломжгүй байна.

Иймд БХГ-ний хайгуул болон ашиглалтын хугацааг нарийн тооцож, БХГ-ний хэрэгжилтийг ханган, ӨНЗ-ыг дахин хянаж, дүгнэлт ирүүлэхийг зөвлөв.

## **2.5. ПЕТРОМАТАД ХХК-ИЙН МАТАД ХХ ТАЛБАЙН 2022 БХГ-НД ЗААСАН ТӨЛБӨР, УРАМШУУЛЛЫГ ХУГАЦАА ХОЦРООЖ ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН БАЙНА.**

### **Орлого төвлөрүүлэлт:**

Тайлант онд Газрын тосны тухай хуулийн 34 дүгээр зүйл, БХГ-ний 13 дугаар зүйлд заасан урамшуулал, үйлчилгээний хөлс, бусад төлбөр 86,800.00 ам.долларыг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 66,835.29 ам.долларыг төвлөрүүлж, сургалтын төлбөрийн дутуу 14,876.71 ам.долларын төлбөрийг 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр, орон нутгийг хөгжүүлэх урамшууллын үлдэгдэл 5,088.00 ам.долларыг 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр буюу хугацаа хоцроож нөхөж төлсөн байна.

АМГТГ нь гэрээлэгчийн тайлант онд төсөвт төвлөрүүлэх орлого, үлдэгдлийн дүнг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, дүгнэлт тайланд сургалтын төлбөрийн дутуу 14,876.71 ам.долларын төлбөрийг 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр төлсөн талаар тэмдэглэж, орон нутгийг хөгжүүлэх сангийн дутуу төлбөрийг төлөх эсэх талаар дүгнээгүй байна. Энэ нь Газрын тосны тухай хуулийн 9.1.9-д "Газрын тосны борлуулалтын орлогоос ЗГ-т ногдох орлого, энэ хуулийн 30, 31, 34-р зүйлд заасан төлбөр урамшууллыг хугацаанд нь төсөвт төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9, 4 дүгээр зүйлийн 4.1.33-д заасны дагуу гэрээлэгч 2021 оны 6 дугаар сард Голомт банкны эскроу дансанд 12,000.00 ам.доллар байршуулсан байна. Газрын тосны бүртгэл тооцооны журмын 8.5-д "энэ журмын 8.3-т заасан төсвийн дагуу тооцож, эскроу дансанд байршуулсан баталгаа нь тухайн жилийн гүйцэтгэлээр баталгааны дүнгээс дутуу бол нэмж байршуулах, илүү бол дараа жил байршуулах баталгаанд шилжүүлэн тооцно" гэж заасны дагуу гэрээлэгч 2022 онд олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй тул эскроу дансанд мөнгөн хөрөнгө нэмж байршуулаагүй байна.

### **БҮЛЭГ 3. ӨМНӨХ АУДИТААР ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧДЭД ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

Төрийн аудитын байгууллагаас 2014 оноос хойш газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг Петрочайна Дачин Тамсаг ХХК, Доншен газрын тос Монгол ХХК гэсэн 2 гэрээлэгчийн үйл ажиллагаанд тус бүр 2, нийт 4 аудитыг гүйцэтгэхэд:

- *Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2014-2018 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар 30,438,708.94 ам.долларын нөхөн төлбөрийн акт тогтоосон боловч одоог хүртэл биелэгдээгүй, 3 албан шаардлага өгснөөс 2 нь биелсэн, мөн 2019-2021 оны үйл ажиллагаанд хийсэн аудитаар 3 албан шаардлага өгсөн боловч хэрэгжээгүй байна.*
- *"Доншен газрын тос (Монгол)" ХХК-ийн 2014 он, 2015-2018 онуудын үйл ажиллагаанд хийсэн 2 удаагийн аудитаар 3 албан шаардлага өгч, аудитын шийдвэрийг хэвээр үлдээх талаар Улсын дээд шүүхийн шийдвэр гарсан хэдий ч өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байна.*

Дээрх 2 гэрээлэгчийн 2014 оноос хойших үйл ажиллагаанд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын биелэлт 0 хувь, албан шаардлагын биелэлт 22.2 хувь, Ашигт малтмал, газрын тосны газарт өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 82.3 хувьтай байна.

## Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Доншен газрын тос Монгол ХХК-ийн БХГ-97 талбайгаас 2019-2021 онд 1,066,556.7 баррель газрын тос олборлож, нийт 1,003,983.27 баррель газрын тос борлуулж, борлуулалтын зардлыг 3,795,417.35 ам.доллар, нийт борлуулалтыг 48,659,202.03 ам.доллароор тус тус баталгаажуулав.
2. Мөн БХГ-97 талбайгаас МУЗГ-т ногдох нийт орлого 13,692,082.27 ам.доллар төвлөрүүлэхээс роялти 3,649,440.15 ам.доллар, ашигт газрын тос 9,899,106.42 ам.доллар, өртөгт газрын тосыг 143,535.70 ам.доллар гэж баталгаажуулсан.
3. Петроматад ХХК-ийн Матад ХХ талбайн хайгуулын хугацаанаас ашиглалтын хугацаанд шилжих үеийн БХГ-ний заалтуудыг мөрдөөгүй, БХГ-нд заасан хугацаанд олборлох үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар хугацааны хоцрогдлыг арилгах талаар АМГТГ-т өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалж ӨНЗ-ыг баталгаажуулах боломжгүй байна.
4. АМГТГ-аас гэрээлэгчийн БХГ-ний дагуу уламжлалт болон уламжлалт бус газрын тосны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт тайлан ирүүлж байгаа боловч хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, дүгнэж тайлагнах заавар аргачлалгүй, хянах үйл ажиллагааны системгүйгээс харилцан адилгүй байна.
5. АМГТГ гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, газрын тосны экспорт, борлуулалтын орлого зөрүүтэй байхад хянан шалгаж, дүгнэлт тайланд бүрэн тусгаагүй байгаа нь БХГ-ний хэрэгжилт хангагдахгүй байх, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ харилцан биелүүлэхгүй байх үр дагавар үүсэж байна.
6. Өмнөх аудитаар газрын тосны олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчдэд тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

## **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

### **Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад:**

1. АМГТГ хяналт шалгалтыг хэрхэн хийх, дүгнэх, тайлагнах талаар мөрдөх заавар, аргачлал батлах;
2. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах, улсын дээд шүүхийн гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

### **АМГТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Ганхуяг:**

1. АМГТГ хяналт шалгалтыг хэрхэн хийх, дүгнэх, тайлагнах талаар мөрдөх заавар, аргачлал боловсруулж, батлуулах, хяналтын үйл явцыг программчлах арга хэмжээ авах;
2. Гэрээлэгчдэд хийж буй хяналт шалгалтыг газрын даргын тушаалаар Ажлын хэсэг байгуулах бус хариуцсан газар, хэлтсийн үндсэн үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтээр хэрэгжилтийг хангах;
3. Гэрээлэгчийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, газрын тосны экспорт, борлуулалтын орлого зөрүүтэй байвал хянан шалгаж, зөрүүтэй асуудлыг дүгнэлт тайланд бүрэн тусгаж ирүүлж байх;
4. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгчдийн газрын тос олборлох технологид ашиглагдаж буй усны заалт болон төлбөрийн нэхэмжлэхийг цооног, худгийн байршлаар нь ангилж нэгтгэж нийт ашигласан усны тооцоог гаргаж, оролцогч талуудын жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулж акт үйлдэх, тус аудитаарх акт болон гэрээлэгчийн АМГТГ-тай хийсэн протоколын дүнгийн зөрүүг тодорхойлж, арга хэмжээ авч ажиллах;
5. Матад ХХ талбайн БХГ-ний дагуу хайгуул болон ашиглалтын хугацаатай уялдуулж, БХГ-ний хэрэгжилтийг хангаж, ӨНЗ-ыг дахин хянан дүгнэж ирүүлэх;
6. Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтыг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх.